



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 07

№ 04/18

Улаанбаатар хот

ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ ТАНАА

аймгийн сумын 5 дугаар багийн иргэн "...2022 оны 08 дугаар сарын 22-ний өдөр аймаг дахь "ийн кассын хажуугийн шалан дээрээс улаан өнгийн түрийвч олж аваад эзэнтэй нь холбоо барьж чадахгүй байж байтал "Увс аймгийн Нэгдсэн групп" цахим сүлжээнд миний зураг тавигдаж, түрийвчийг авсан байж болзошгүй гэх сэтгэгдэл олон нийтэд төрүүлж, нэр төрийг гутаасан. Камерын бичлэгийг иргэний хүсэлтийн дагуу дур мэдэн өгч, ийм боломжийг бүрдүүлсэн худалдааны төвийн камерын хянагчийн үйл ажиллагаанд гомдолтой байна" гэх гомдлыг Комисст гаргажээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Комиссын аймаг дахь референт 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр аймаг дахь "ийн гүйцэтгэх захирал, харуул хамгаалалтын албаны захирал, камерын хянагч нараас амаар болон бичгээр тайлбар авч, гомдол шалгах ажиллагааг явуулахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна.

1. аймгийн сумын 12 дугаар багт байрлах "Номин агуулах худалдаа"-ний төвийн камерын хянагч нь иргэн А, Н нарт камерын бичлэгийг үзүүлж, зургийг нь утсан дээрээ дарж авах боломжийг олгожээ. Улмаар иргэн Н гар утсан дээр авсан зургаа " олон нийтийн фейсбүүк сүлжээнд байршуулсан байна.

2. Камерын хянагч нь тус худалдааны төвөөр үйлчлүүлж байхдаа эд зүйлсээ алдсан, гээгдүүлсэн хүмүүс хүсэлт гаргасан тохиолдолд камерын бичлэгийг чөлөөтэй шүүж өгдөг бөгөөд 2022 онд 20 орчим хүнд бичлэг шүүж өгсөн, камерын бичлэг хадгалах, хянахтай холбоотой тусгайлсан дүрэм журам тус компанид байдаг эсэхийг мэдэхгүй гэх тайлбарыг Комисст өгсөн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт "халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. ...иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална" гэж, Монгол Улс 1974 онд соёрхон баталсан Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд "Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар

150060051



халдахыг хориглоно. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж Монгол Улсын иргэний эдлэх хүний эрхийг баталгаажуулжээ.

Энэхүү хүний эрхийг хэрэгжүүлэх хүрээнд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ний өдөр батлагдаж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад хуульд заасны дагуу, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг “мэдээлэл хариуцагч” гэж тодорхойлсон бөгөөд иргэн [redacted] холбоотой камерын бичлэгийн тухайд [redacted] ХХК нь мэдээлэл хариуцагч болох юм. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад “хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх”, “хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх”, “мэдээллийг хуульд заасан үндэслэлээр, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу цуглуулах, боловсруулах, ашиглах” зарчмуудыг мөрдөх, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “хуульд нийцүүлэн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах журам баталж, мөрдүүлэх”, “мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах талаар мэдээллийн эзэн, хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллага, гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээх” зэрэг мэдээлэл хариуцагчийн хүлээх 15 төрлийн үүргийг тодорхойлжээ. Уг хуулийн 24 дүгээр зүйлд хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих талаар Комиссын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхойлсныг мөн дурдах нь зүйтэй.

[redacted] нь худалдааны төвийн камерт авагдсан бичлэгийг хэрхэн хамгаалах, ашиглах, харилцах тухай тодорхой чиглэлийг холбогдох ажилтандаа өгөөгүй нь хүний эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн, Увс аймаг дахь [redacted]-ийн камерын хянагч [redacted] иргэн [redacted] холбогдох камерын бичлэгийг хүсэлт гаргасан иргэдэд гаргаж өгсөн нь түүний нэр төрийн халдашгүй байх эрхийг зөрчсөн байна.

Гомдол шалгах ажиллагааны хүрээнд тогтоогдсон хүний эрхийн зөрчлийг арилгуулах, цаашид энэ төрлийн хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 24 зүгээр зүйлийн 24.1.1, 24.1.2 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн дагуу дараах арга хэмжээ авахыг шаардаж байна.

1. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг зөрчиж, иргэн [redacted] нэр төр халдашгүй байх эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн камерын хянагч [redacted], энэ асуудлыг шууд удирдлагаар хангаж ажиллах чиг үүрэгтэй албан тушаалтанд хариуцлага тооцох.

2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн камерын бичлэгийг хадгалах, хамгаалах, ашиглах харилцааг зохицуулсан компанийн дотоод журмыг шинээр боловсруулж, мөрдүүлэх, компанийн бүх ажилтнуудад сурталчлах, хувийг Комисст ирүүлэх.

3. [redacted] ХХК-ны нийт салбар байгууллагын харуул хамгаалалтын нэгжийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд хүний хувийн мэдээллийг хамгаалах, хуулийн байгууллага шаардсанаас бусад тохиолдолд болон мэдээллийн эзний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хүний хувийн мэдээллийг бусдад дамжуулах, задруулахыг хориглосон зохицуулалтыг нэмж тусгах.



4. Тус компанийн хэмжээнд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн талаар нийт ажилтнуудад үе шаттай сургалт зохион байгуулах.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт "Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй" гэж заасан. Шаардлагын дагуу авсан арга хэмжээний танилцуулгыг холбогдох баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

Шаардлагад тусгагдсан сургалт, сурталчилгааны ажлыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд энэ талаар төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн талаараа тодорхой хугацаанд Комисст дахин мэдээлэл ирүүлж болно.

ГИШҮҮН



Г.НАРАНТУЯА